

Үнэлэх: Одоогийн үнэлгээ:

[Сэтгэгдэл](#) [Илгээх](#) [Хэвлэх](#)


いいね! 1

0

С.Батболдын Японд хийх албан ёсны айлчлал эхэлж байна

Өчигдөр 15 цаг 36 минут

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын Япон улсын Засгийн газрын урилгаар тус улсад хийх албан ёсны айлчлал өнөөдөр буюу 2012 оны гуравдугаар сарын 11-ний энд өдөр эхэлж байна.



Энэ нь Монгол Улс, Япон Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойт тэмдэглэх хүрээнд болж буй өндөр дээд хэмжээний айлчлал юм.

Хоёр орны харилцаа, хамтын ажиллагааны ойрын болон хэтийн зорилт, ялангуяа уул уурхай, эрдэс баялаг, дэд бүтэц, эрчим хүч болон хөдөө аж ахуй, байгаль орчин, хүний нөөцийн салбарт хамтран ажиллах чиглэлийг нарийвчлан тодорхойлох, Монгол, Японы худалдаа, Эдийн засгийн хамтын ажиллагааг цогц хэлбэрээр хөгжүүлэхэд тулхэц болох Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (EPA) байгуулах тухай албан ёсны хэлэлцээг эхлүүлэх, Монгол Улсын эдийн засгийн тогтвортойлтуулж, хөгжлийг дэмжих зээлийн төслийн 2-р ээлж болох Нийгмийн халамжийн салбарт зориулсан 20 сая ам.долларын зээлийн 1 төсөл, мөн буцалтгүй тусламжийн 3 төслийг хэрэгжүүлэх асуудлыг тохиролцож шийдвэрлэхэд чиглэж байгаагаараа айлчлал ач холбогдолтой юм.

[Шинэ мэдээ](#) [Их уншсан](#) [Их](#)

 news.mn

Ээлжит бус чуулганы үр дүнгийн
-51 минутын өмнө

ЭОНН-ыг улсын бүртгэлд бүртгэх
-20 минутын өмнө

Улсад ажилласан жилээ нөхчүү
-36 минутын өмнө

ИЗН-ын нэр, дүрмийн өөрчлөлт
-41 минутын өмнө

“Намуудын авсан илүү хандившилжүүльье!”
-3 минутын өмнө

Шударгаар өрсөлдөцгөө!
-22 минутын өмнө

“Эмэгтэй улстөрчид тэргүүлэх
0 минутын өмнө

Эмэгтэйчүүд шударга ёсны төлөө
8 минутын өмнө

Эмэгтэйчүүдийн хөдөлгөөний
болж байна
53 минутын амна

Санал асуулга

Засгийн газраас баталсан нийтийн
ноолуурын 300 тэрбум бондийн
дэмжиж байна үү?



Айлчлалын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд Японы Утсаа залгамжлах Хунтайж Нарухитод бараалхаж, Япон Улсын Ерөнхий сайд Ё.Нода-тай албан ёсны хэлэлцээ хийнэ.

Мөн Япон Улсын Парламентын Төлөөлөгчдийн танхимын дарга Т.Ёкомичи болон Зөвлөхүүдийн танхимын дарга К.Хирата нарт бараалхаж, Гадаад хэргийн сайд К.Гэнба, Эдийн засаг, үйлдвэрийн сайд Ю.Эдано нартай уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцно.

Японы зүүн бус нутагт болсон байгалийн гамшигаас хойш яг нэг жил өнгөрч байна. Үүнтэй холбогдуулан өнөөдөр Японы Цог Жавхлант Эзэн хаан болон Япон Улсын Ерөнхий сайд нар оролцон Токио хотноо зохион байгуулагдах Гамшигт амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх цуглаанд Монгол Улсын Ерөнхий сайд оролцно.

Түүнчлэн Японы Эдийн Засгийн байгууллагуудын холбоо (КЭЙДАНРЭН)-ны удирдлага болон Япон Улсын томоохон компанийн төлөөлөгчидтэй хийх уулзалт айлчлалын хөтөлбөрт мөн багтсан бөгөөд Монголын нүүрс, уран, газрын ховор элементийн орд газруудыг хамтран ашиглах, эрчим хүч, темер зам зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтад хөрөнгө оруулалт хийх болопцоо нөхцөлийн талаар санал солилцох юм.



Ерөнхий сайд Японы “NHK” телевиз болон Никкэй, Санкэй, Майнichi сонинд ярилцлага өгнө.

Ерөнхий сайд Осака мужид зочилж, Осака хот дахь Монгол Улсын Ерөнхий консулын газрын нээлтэд оролцох юм гэж **Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албанаас мэдээллээ.**

**Монгол Япончуудын харилцаанд агаарын
тээвэр гүүр болох учиртай гэдгийг Ерөнхий сайд хэллээ**

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын Япон улсад хийх албан ёсны айлчлалаа товлосон хугацаанаасаа нэг өдрийн өмнө эхэлж байна. Энэ ч учиртай юм.

Японы зүүн бус нутагт болсон байгалийн гамшигаас хойш яг нэг жил өнгөрч байна. Үүнтэй холбогдуулан өнөөдөр Японы Цог Жавхлант Эзэн хаан болон Япон Улсын Ерөнхий сайд нар оролцон Токио хотноо зохион байгуулагдах Гамшигт амь үрэгдэгсийн дурсгалыг хүндэтгэх цуглаанд Ерөнхий сайд С.Батболд оролцож Монголын ард түмнийхээ чин сэttэлийн хүндэтгэлийг илэрхийлж байгаа юм.

Гуравдугаар сарын 11-ний ням гаригийн энэ өдөр Ерөнхий сайд С.Батболд Япон улсын хувийн хэвшлийн нэр бүхий томоохон компаниудын удирдлагуудыг хүлээн авч уулзлаа.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод “ANA”компанийн ерөнхийлөгч Ш.Ито, тус компанийн гүйцэтгэх дэд ерөнхийлөгч К.Ода, Гадаад харилцаа хариуцсан дэд ерөнхийлөгч К.Шибата нар бараалхлаа.

ANA бол олон улсад нэр хүндтэй компани. Монгол Улс ANA компанийт агаарын тээврийн салбарт идэвхтэй хамтын ажиллагаа өрнүүлэх сонирхолтой байгаа юм. Тус компани нь Монголын агаарын тээврийн Изинес компанийтай хамтын ажиллагааны гэрээ байгуулан дотоодын нислэгийг дэмжих чиглэлээр ажилладаг. Монголын эдийн засаг эрчимтэй хөгжжик байна. Энэ хөгжлийг улам хурдасгахад далайд гарцгүй орны хувьд агаарын тээврийн гүйцэтгэх үүрэг чухал гэдгийг Ерөнхий сайд С.Батболд тэмдэглээд аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлснээр хоёр улсад харилцан зорчих жуулчдын тоо нэмэгдэнэ гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийллээ.

Мөн монгол орон ардчилал, зах зээлийн замыг сонгосон үеэс шилжилтийн хүндрэлийг даван туулахад Япон улсын Засгийн газар, ард түмнээс үзүүлж ирсэн тусlamж, дэмжлэгт Монголчууд талархдаг төдийгүй япончуудад элэгсэг дотно ханддаг. Тиймээс хоёр орны иргэдийн ийм дотно харилцаанд агаарын тээвэр гүүр болох учиртай гэдгийг ч дурдаж байлаа.



ANA компанийн Ерөнхийлөгч техник, технологи нэвтрүүлэх, боловсон хүчиний сургалт, хөрөнгө оруулалт хийхэд голлон анхаарч ажилладаг, энэ чиглэлээр Монгол Улстай хамтран ажиллах эрмэлзэлтэй байгаа. Үүнийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газар дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байгаагаа илэрхийллээ.

Засгийн газрын тэргүүн С.Батболд ANA компани нь Нарита болон Кансайн нисэх буудал дахь Монголын МИАТ компанийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж байгаад талархаж байгаагаа уулзалтын үеэр тэмдэглэлээ.

Мөн Монгол Японы хооронд шууд нислэг бий болох нь бүх талын харилцаа хамтын ажиллагаа идэвхтэй

Японд төвтэй, дэлхийн 80 орчим оронд 200 гаруй салбартай, 500 гаруй охин компанийтай Мицубиши корпорацийн ерөнхийлөгч К.Кобаяши төлөөлөгчдийнхөө хамтаар Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод мөн өнөөдөр бараалхлаа.

Монгол Японы стратегийн түншлэлийн харилцааг эдийн засгийн агуулгаар баяжуулахад идэвхтэй хамтран ажиллана гэдэг итгэлтэй байгаагаа Ерөнхий сайд С.Батболд илэрхийллээ.


Мицубиши корпорацийн ерөнхийлөгч уулзалтын үеэр бизнесийн төдийгүй боловсон хүчин зэрэг бусад хэлбэрээр хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байгаагаа тэмдэглэж байлаа.

Японы хэвлэлүүд Монгол Улсын Ерөнхий сайдын айлчлалыг ихээхэн сонирхож байна

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдын Япон улсад хийж байгаа албан ёсны айлчлал тус улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудын анхаарлын төвд байна. Японы NHK телевиз, өдөр тутмын хамгийн нэр хүндтэй сонин болох "Никкэй" болон "Майнichi" сонины сэтгүүчид өнөөдөр Ерөнхий сайдас тусгайлан ярилцлага авлаа

Монгол Улсын эдийн засгийн өндөр хурдтай өсөлт, цаашдын төлөв байдал, бүтээн байгуулалтын чанартай томоохон төслүүд түүний дотор Тавантолгойн асуудлыг Японы сэтгүүчид ихээхэн сонирхож байна.

Тавантолгойн баруун, зүүн цанхи дахь үйл ажиллагаа, олон улсын нээлттэй тендерийн явц, түүн дэх Японы оролцооны талаар Ерөнхий сайд С.Батболдын байр суурийн талаар тэд мөн асууж байлаа.



Олон улсын нээлттэй тендерийн үйл ажиллагаа ном дүрмийн дагуу явж байгаа. Яриа хэлэлцээний явц амаргүй нөхцөлд байгаа ч Тавантолгойг Монгол Улсад ашигтайгаар Монголын ард түмний хүсэл сонирхлыг харгалzan шийдэх учиртай. Мөн хөрөнгө оруулагч талуудын байр суурийг ч хүндэтгэн үзэж асуудалд хандаж байгаа гэдгээ Ерөнхий сайд хэлээд энэ ондоо багтааж төслийг хэрэгжүүлж эхлэх төлөвлөгөөтэй байгаагаа хэллээ.

Түүнчлэн энэ айлчлалын зорилго, үр дүн болоод Солонгосын хойгийн асуудал ч сэтгүүлчийн сонирхсон сэдвийн нэг байлаа.

Ерөнхий сайд С.Батболд байгалийн гамшигт амь үрэгдсэн иргэдийн дурсгалыг хүндэтгэх арга хэмжээнд оролцлоо

Одоогоос яг нэг жилийн өмнөх өдөр буюу 3 дугаар сарын 11-ний өдөр Японы Зүүн бүс нутагт хүчтэй газар хөдлөлт болсны улмаас 16 мянга гаруй хүн нас барж япон улсын эдийн засаг, нийгмийн амьдралд асар их гамшиг учирсан. Байгалийн гамшигт амь үрэгдэгсдийн гэгээн дурсгалыг энэ өдөр япончууд хүндэтгэн мэхийн ёсолж, тэдний гэр бүлийнхэн, төрөл төрөгсдөд гүн эмгэнэл илэрхийж байна.

Япон Улсын Үндэсний театрт амь үрэгдэгсдийг хүндэтгэх ёслолын ажиллагаа болж Японы Цог Жавхлант

Хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын тэргүүн оролцсон нь гадаадын төлөөлөгчдийн дундаас хамгийн өндөр түвшний зочин хүндэтгэл үзүүлсэн нь энэ байлаа.

Энэхүү ёслолын ажиллагаа Токиогийн цагаар 14.30-д Эзэн хаан морилон ирснээр эхэлж, Японы Төрийн дуулал хөгжимд эгшиглэхэд цугласан хүмүүс хүндэтгэн босож дуулцгаалаа. Үүний дараагаар 14 цаг 46 минутад амь үрэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэн нэг минут чимээгүй зогслоо.

Япон улсын Ерөнхий сайд Ё.Нода, Эзэн хаан болон амь үрэгдэгсдийн ар гэрийн төлөөлөл уг хэлээд цэцэг өргөх ёслол боллоо. Монгол Улсын Ерөнхий сайд Сүхбаатарын Батболд цэцэг өргөнө хэмээн танхимд танилцуулсны дараагаар тус улс дахь Дипломат төлөөлөгчийн 120 гаруй газрын нэrsийг цагаан толгойн дарааллаар дуудаж танилцуулахад тэргүүнүүд нь хүндэтгэн цэцэг өргөлөө.

Гамшигт өртөж амь наасаа алдсан иргэдээ дурсан санаж, дурсгалыг нь хүндэтгэх энэхүү ёслолын арга хэмжээнд Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд оролцсонд япончууд талархаж байлаа.

“Тэнхлүүн явахад тэмээгээр тусалснаас, тэвдэж явахад тэвнээр тусал” гэсэн монгол ардын зүйр цэцэн уг байдаг. Монгол орон ардчилал, зах зээлийн замыг сонгосон үеэс шилжилтийн хүндрэлийг даван туулахад Монгол Улсын дотно түвш, манай орны “гуравдах хөрш” Япон Улсын Засгийн газар, ард түмнээс үзүүлж ирсэн сэтгэл харамгүй тусламж, дэмжлэгт монголчууд талархаж байдаг юм.

Японы ард түмэнд тохиолдсон энэхүү гамшгийн тухай мэдээг Монголын ард түмэн сэтгэл эмзэглэн хүлээн авч, орон даяар хандивын хөдөлгөөн өрнөж, хүүхэд заплуусаас настан буурал хүртэл бүх хүмүүс эрвийх дэрвийхээрээ мөнгө, хөрөнгө цуглувалж гамшгийн бүсэд илгээж байсан.

Монгол Улсын Засгийн газраас энэ гамшигтай холбогдуулан 2011 оны гуравдугаар сарын 14-ний өдөр Япон Улсын Засгийн газарт 1 сая ам.долларын мөнгөн тусламж үзүүлж, 2500 ширхэг дулаан хөнжил, ноолууран цамц 800, ороолт оймс зэрэг тусламжийн барааг өөрийн онгоцоор Японд хүргэсэн билээ. Мөн хувь хүн, албан байгууллагаас 2 тэрбум 100 сая орчим төгрөг хандивласныг Улаанбаатар дахь Японы Элчин сайдын яаманд гардуулж өгч байсан юм.

Монголын ард түмэн цаашид ч Японы ард түмэнтэй хүнд бэрх цагт ч, хөгжлийн түүхэн үед ч сэтгэл зүрхээрээ үргэлж хамт байх болно гэдгээ Японы хэвлэлүүдэд ярилцлага өгөхдөө хэлсэн. Мөн ажилч хичээнгүй, хөдөлмөрч баатарлаг Японы ард түмэн байгалийн гамшгийн хохирлыг богино хугацаанд даван туулна гэдэгт бид бат итгэлтэй байгаа илэрхийлж байлаа.

Монгол Улсын Засгийн газрын тэргүүний албан ёсны айлчлал 3 дугаар сарын 12-нд эхэлж байгаа ч Японы ард иргэдээд хүндэтгэл үзүүлэх энэхүү ёслолд оролцохын тулд айлчлалаа нэг өдөр урагшлуулсан юм гэж Засгийн газрын Хэвлэл мэдээллийн албанаас мэдээллээ.

Манай сайт танд таалагдаж байвал LIKE хийгээрэй. Танд баярлалаа.

[Send](#)

Bulgan
Bavaraa.

Үнэлэх:

Одоогийн үнэлгээ:

Сэтгэгдэл

Илгээх

Хэвлэх

いいね!

1

0

Холбоотой 5 мэдээ	<<Өмнөх 5 мэдээ	Дараах 5 мэдээ>>
Дурсгалын мод суулгалаа	Ц.Шинэбаяр гишүүн мэдээлэл хийнэ	Долдугаар сарын 1 дахиад болбол яах вэ?
2011 оны 2 сарын 23	Өчигдөр 14 цаг 18 минут	Өнөөдөр 7 цаг 34 минут
Ерөнхий сайд албан ёсны айлчлал хийнэ	Төр, иргэний нийгмийн хурал үргэлжилж байна	Н.Энхбаяр: Би айdag наасаа өнгөрөөсөн
2011 оны 2 сарын 11	2012 оны 3 сарын 10	Өнөөдөр 7 цаг 52 минут
Ноос ноолуурын салбарынхантай уулзав	Ерөнхий сайд Японыг зорилоо	Ц.Шинэбаяр гишүүн мэдээлэл хийнэ
2011 оны 2 сарын 8	2012 оны 3 сарын 10	Өнөөдөр 9 цаг 29 минут
Ерөнхий сайдынх тооллогод хамрагдлаа	Ардаа аягтай чуулган	Төсвийн тодотголыг тайлбарлав
2010 оны 11 сарын 11	2012 оны 3 сарын 10	Өнөөдөр 10 цаг 0 минут
Дээд хэмжээний хэлэлцүүлэгт оролцов	Малчин эмэгтэйчүүд НҮБ-д чууллаа	Ж.Энхбаярын хүртсэн сургамж
2010 оны 9 сарын 24	2012 оны 3 сарын 10	1 цаг 40 минутын өмнө

Сэтгэгдэл:48

Хамгийн шинэ

АНХААРУУЛГА: Уншигчдын бичсэн сэтгэгдэлд news.mn хариуцлага хүлээхгүй болно. Та сэтгэгдээ бичихдээ бусдын эрх ашгийг хүндэтгэн үзнэ үү.

ТЭНЭГ ХҮҮХЭНД

Өнөөдөр 8 цаг 0 минут

ХЭЭХ ЭНЭ ЮУ ВЭ. МОНГОЛЫН АЛЬ Ч ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА АЖИЛЧИДАА ЖИНСЭН ӨМД ӨМСӨХИЙГ ХОРГИЛДОГ ШҮҮ ДЭЭ. ЭНЭ СЭТГҮҮЛЧ ХҮҮХЭН ЮУ ВЭ. МОНГОЛ УЛСАА ДОРОМЖЛООД БАЙГАА Ч ЮМ ШИГ ЕРӨНХИЙ САЙДАА ДООШ НЬ ХИЙГЭЭД Ч БАЙГАА ЮМ ШИГ. ЭНЭ БАЙТУГАЙ ЮМИЙГ АНЗААР Ч ЯВДАГ ЕРӨНХИЙ САЙД ХУВЬ ЗАЯТАЙГАА ЭВЛЭРСЭН ЮМ БОЛОВ УУ.

0 0

ТЭНЭГ ХҮҮХЭНД

Өнөөдөр 8 цаг 0 минут

ХЭЭХ ЭНЭ ЮУ ВЭ. МОНГОЛЫН АЛЬ Ч ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА АЖИЛЧИДАА ЖИНСЭН ӨМД ӨМСӨХИЙГ ХОРГИЛДОГ ШҮҮ ДЭЭ. ЭНЭ СЭТГҮҮЛЧ ХҮҮХЭН ЮУ ВЭ. МОНГОЛ УЛСАА ДОРОМЖЛООД БАЙГАА Ч ЮМ ШИГ ЕРӨНХИЙ САЙДАА ДООШ НЬ ХИЙГЭЭД Ч БАЙГАА ЮМ ШИГ. ЭНЭ БАЙТУГАЙ ЮМИЙГ АНЗААР Ч ЯВДАГ ЕРӨНХИЙ САЙД ХУВЬ ЗАЯТАЙГАА ЭВЛЭРСЭН ЮМ БОЛОВ УУ.

0 0

モンゴル首相が日本訪問

Өнөөдөр 7 цаг 7 минут

モンゴルの首相バトボルド（モンゴルのウランを開発し、原発建設によって経済を発展させる路線を提唱した首相）が3月10日から15日の間、日本訪問。ウラン開発と初めての原発建設の協力関係を築くのだそうです。今年は日本モンゴル外交樹立40周年。情けない限りです。モンゴル政府は去年の核廃棄物問題に終止符をうつために外国の核のゴミは受け入れないと言いましたが、ウラン輸出と原発建設は否定しませんでした。いつかは発表するのだろうと思っていましたが、この時期ですか？と目を疑いました。

0 0

zochin

Өнөөдөр 6 цаг 32 минут

Eronkhii said Mongoliin neriig gargakhaar saikhan bolovsroltoi, olon ulsiin ediin zasagch, olon khelnii bolovsroltoi, saikhan kharagdaj bna. Mongol khogjino shuu.

1 0

Зочин

Өнөөдөр 5 цаг 50 минут

oyunchimeg iim muuhai buduuleg soyolgui hernee neg ih zuragtaar garch, gerel zurgand urtuh durtai, yostoi uher mal emegtei. mongolyn saihan huuhnuud, mongol saihan setguulchdiin neriig buzarlasan amitan boliosoi. bas hulgaich, hadalch hun shuu dee. aimshgiin hulgaich, yamar hadalch gedgiig ni undesnii televiziinhen medne dee, hehehehe

0 0

Америк нөутбүүкний төв Компьютер Ланд 321 тоот

Өнөөдөр 5 цаг 7 минут

гол нь маш өргөн сонголт, хамгийн хямд үнэ, 1 жилийн баталгаа, баахан бэлэгтэй. 100 хувь orig америк нөутбүүкний төв. Компьютер ланд, 321 тоот, 3 давхарт, хойд шатны хажууд,

0 0

Америк нөутбүүкний төв Компьютер Ланд 321 тоот

Өнөөдөр 5 цаг 7 минут

гол нь маш өргөн сонголт, хамгийн хямд үнэ, 1 жилийн баталгаа, баахан бэлэгтэй. 100 хувь orig америк нөутбүүкний төв. Компьютер ланд, 321 тоот, 3 давхарт, хойд шатны хажууд....

0 0

Америк нөутбүүкний төв Компьютер Ланд 321 тоот

Өнөөдөр 5 цаг 7 минут

гол нь маш өргөн сонголт, хамгийн хямд үнэ, 1 жилийн баталгаа, баахан бэлэгтэй. 100 хувь orig америк нөутбүүкний төв. Компьютер ланд, 321 тоот, 3 давхарт, хойд шатны хажууд....

0 0

3/12/12 С.Батболдын Японд хийх албан ёсны айлчлал эхэлж байна
тогтнүү маш эргэн сонголт, хамгийн хямц үнэ, тэжиллийн өтгөлжилэл, өмчийн оршиг тэй. Тус хувь оршиг
америк нөутүүкний төв. Компьютер ланд 321 тоот, 3 давхарт, хойд шатны хажууд....

0 0

Гелег

Өнөөдөр 5 цаг 1 минут

Энэ шуналтай гелег Таван толгойгоос ендер хувь енгнегэж яонуудыг хошгоруулаад хажуугаар нь
еерийнхэе бизнесийг яриад явж байгаа даа

0 0

Зочин

Өнөөдөр 1 цаг 4 минут

Mongolyn setguulch jiinstei suuj bna, yu be, oyunchimegee ooriihoo bish yumaa gehed ulsynhaa neriig
bodooch tenegee

0 0

Зочин

Өнөөдөр 2 цаг 20 минут

english-sources.blogspot.com - АНГЛИ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛ

0 0

MGL

Өнөөдөр 1 цаг 1 минут

Япон улс манай орныг ядарч байхад хамгийн их тусалсан орон шүү дээ Ерөнхий сайдын айлчлалд
амжилт хүсье, юум хийж байгаа хүнээ битгий муулаач Монголчуудаа

0 0

MGL

Өнөөдөр 1 цаг 1 минут

Япон улс манай орныг ядарч байхад хамгийн их тусалсан орон шүү дээ Ерөнхий сайдын айлчлалд
амжилт хүсье, юум хийж байгаа хүнээ битгий муулаач Монголчуудаа

0 0

зочин

Өчигдөр 21 цаг 49 минут

Япон болон гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр Батболдын айлчлалын гол зорилгыг - японы
тусламжтай атомын станц барих цөмийн шаар булах байгууламж барих Японоос их хэмжээний зээл
авах газрын ховор элемент ба ураны олборлолт гэж бичиж байнаа МАН-ын засгийн газар ард
түмэнтэйгээ зөвлөхгүй атомын станц барих байгаль орчинд хортой ураны олборлолтын талаар
гадныхантай тохиород байвал МАН-ын УЗ-ийн гишүүн бүр хариуцлагыг хүлээнэ шүү Хонгор сумынхныг
хамгаалж чадаагүй МАН ард түмнээ нутаг усаа бурэн хордуулнаа

0 0

irgen

Өчигдөр 17 цаг 31 минут

Ach holbogdolgui uulzaltuuud I hiigeed baih yum daa. Bodit ajil baihgui ni haramsaltai yum. Batbold juldaad
baina uu esvel ulsyn nereer huviinhaa ajlyg amjuulj yavdag yum uu.

0 0

ekh oron

Өчигдөр 16 цаг 37 минут

Tsomiin hayagdal bulakh gereni tsag tulad evgui bn te gereni dagu ochij bn te songulin mongo olokh ged

0 0

Зочин

Өчигдөр 16 цаг 17 минут

Энэ хулгайч, луйварчин Японд очиж юу хийх гэж яваа бол доо. Цөмийн хаягдал Монголд авчирахаар
явсан ч байж магадгүй

Энэ хулгайч, луйварчин Японд очиж юу хийх гэж яваа бол доо. Цөмийн хаягдал Монголд авчирахаар явсан ч байж магадгүй.

0 0

Зочин

Өчигдөр 14 цаг 56 минут

Nugoo atiraar bor n irjuu? Unetei delguuruud heseed alga bolsnuu? Hungen hogiin huuhen...

0 0

Freedom

Өчигдөр 14 цаг 36 минут

tsunamiin ayul bolson har udur ailchilal ni taarch | bdag Heden doldoich nam dagaj hooloo olj iddeg zahialgat setgegdelchid icheesei 3 Saryn daraa manai uls turd jinhene tsunami uusch MAN ustaj uls guren maani tsevershih boltugai

0 1

Зочин

Өчигдөр 15 цаг 31 минут

cham shig yummuuud iiim | yum bodno doo. Yumiig tsaanatai naanatai bodoj bichjii. yugaa ch medehgui baj bitii net-d orjii

0 0

Freedom

Өчигдөр 14 цаг 35 минут

tsunamiin ayul bolson har udur ailchilal ni taarch | bdag Heden doldoich nam dagaj hooloo olj iddeg zahialgat setgegdelchid icheesei 3 Saryn daraa manai uls turd jinhene tsunami uusch MAN ustaj uls guren maani tsevershih boltugai

0 2

Freedom

Өчигдөр 14 цаг 35 минут

tsunamiin ayul bolson har udur ailchilal ni taarch | bdag Heden doldoich nam dagaj hooloo olj iddeg zahialgat setgegdelchid icheesei 3 Saryn daraa manai uls turd jinhene tsunami uusch MAN ustaj uls guren maani tsevershih boltugai

1 1

Mongolian

Өчигдөр 13 цаг 51 минут

Saya MGLchuudtai hiisen uulzaltand ochoood irlee. Manai PM er ni dajgui shuu. Elbegee shig huniig huurchih baidal ajiglagdahgui baina.

0 0

Зочин

Өчигдөр 12 цаг 39 минут

Энэ хүн үнэхээр том улс төрч болжээ. Итгэл харагдаж байна. Итгэж болохоор байна. Монгол хөгжих юм байна

0 0

Mongolian

Өчигдөр 13 цаг 52 минут

Saya MGLchuudtai hiisen uulzaltand ochoood irlee. Manai PM er ni dajgui shuu. Elbegee shig huniig huurchih baidal ajiglagdahgui baina.

0 0

Зочин

Өчигдөр 11 цаг 55 минут

0 0

kh
.....
.....

Өчигдөр 11 цаг 54 минут

ene setgegdel bichij baigaa humuust yamar ch uhalsar algaa. Mungu avch setgegdel bichsen hulduu tolgoitoi iumnuud

0 0

Зочин
.....
.....

Өчигдөр 11 цаг 44 минут

БИТГИЙ Л ЦӨМИЙН ХАЯГДАЛ БУЛАХ ГЭРЭЭ ХИЙЧИХЭЭРЭЙ ГӨЛӨГ МИНЬ. ХЭРЭВ ХИЙВЭЛ НААД АРАЛТАЙГАА ЖИВЖ БАЙХДАА ТААРСАН ЯПОНЧУУДТАЙГАА ХАМТ ЗАЙЛААРАЙ НОВШ МИНЬ УХЛИЙН МУУГААР ҮХЭХ ЦАГ ЧИНЬ ИРНЭ ШҮҮ

0 2

дээдэх хужаад
.....
.....

Өчигдөр 12 цаг 34 минут

Хөөе цөм мөм гээд байгаа хужаа минь одоохон сайтаас гар. Энд Монгол сайдын талаар бичсэн байна. лалар гэж

0 0

Зочин
.....
.....

Өчигдөр 11 цаг 43 минут

БИТГИЙ Л ЦӨМИЙН ХАЯГДАЛ БУЛАХ ГЭРЭЭ ХИЙЧИХЭЭРЭЙ ГӨЛӨГ МИНЬ. ХЭРЭВ ХИЙВЭЛ НААД АРАЛТАЙГАА ЖИВЖ БАЙХДАА ТААРСАН ЯПОНЧУУДТАЙГАА ХАМТ ЗАЙЛААРАЙ НОВШ МИНЬ УХЛИЙН МУУГААР ҮХЭХ ЦАГ ЧИНЬ ИРНЭ ШҮҮ

0 0

Зочин
.....
.....

Өчигдөр 15 цаг 33 минут

tiim yum yeroosoo baihgui. Ugaasaa olon ulsiin jishig, huuli togtoomj unsh

0 0

Зочин
.....
.....

Өчигдөр 11 цаг 43 минут

БИТГИЙ Л ЦӨМИЙН ХАЯГДАЛ БУЛАХ ГЭРЭЭ ХИЙЧИХЭЭРЭЙ ГӨЛӨГ МИНЬ. ХЭРЭВ ХИЙВЭЛ НААД АРАЛТАЙГАА ЖИВЖ БАЙХДАА ТААРСАН ЯПОНЧУУДТАЙГАА ХАМТ ЗАЙЛААРАЙ НОВШ МИНЬ УХЛИЙН МУУГААР ҮХЭХ ЦАГ ЧИНЬ ИРНЭ ШҮҮ

0 0

Зочин
.....
.....

Өчигдөр 10 цаг 50 минут

Сурвалжлагчийн асуултад Солонгост суух Д.Гэрэл Элчин сайд хариулж байна.солонгос, монгол нэг үндэстэн гэдэг нь бол түүхийн бичиг, баримтаас нотлогдчихсон юм шүү дээ. Энэ нь бол олон олдвор байгаа, түүхийн бичиг, баримтууд байгаа, эрдэмтэд энэ дээр өөрсдийнхөө дүгнэлтийг гаргачихсан байгаа. Судалгаанаас аваад үзэхэд ер нь холбоотой байсан. Жишээлбэл ганцхан л зүйлийг дурдахад олон хаад, ноёдууд эхнэр, хатнаа авдаг байсан. Ийм уламжлалууд байсан. Энэ нь ер нь харилцаа, холбоотой байнсны нотолгоюм. Түүнээс гадна хэлний хувьд авч үзэхэд эд нар алтайн язгууртай, ижил төстэй үгнүүд маш их бий. Та нар ирээд анзаарсан байх. Баруун, зүүн гзхэд яг л тэрүүгээрээ хэлж байх жишигээтэй. Жишээлбэл Зэжү арап дээр жоохон хязгаарлагдмал, гадны нөлөө орох боломжгүй газар бол 200 гаруй монгол уг байдаг гэсэн. За энийг нотолсон. Өөрөөр хэлбэл 200 уг гэдэг бол бараг л ярчихаж болохоор монгол уг байна..гэж хэлээд сууж байна

0 0

Зочин
.....
.....

Өчигдөр 12 цаг 35 минут

үнэн юм чинь яах юм мал минь

0 0

3/12/12 С.Батболдын Японд хийх албан ёсны айлчлал эхэлж байна

байгаа, түүхийн бичиг, баримтууд байгаа, эрдэмтэд энэ дээр өөрсдийнхөө дүгнэлтийг гаргачихсан байгаа. Судалгаанаас аваад үзэхэд ер нь холбоотой байсан. Жишээлбэл ганцхан л зүйлийг дурдахад олон хаад, ноёдууд эхнэр, хатнаа авдаг байсан. Ийм уламжлалууд байсан. Энэ нь ер нь харилцаа, холбоотой байсны нотолгоо юм. Түүнээс гадна хэлний хувьд авч үзэхэд эд нар алтайн язгууртай, ижил тэстэй үгнүүд маш их бий. Та нар ирээд анзаарсан байх. Баруун, зүүн гэхэд яг л тэрүүгээрээ хэлж байж жишээтэй. Жишээлбэл Зэжү арап дээр жоохон хязгаарлагдмал, гадны нэлэө орох боломжгүй газар бол 200 гаруй монгол уг байдаг гэсэн. За энийг нотолсон. Өөрөөр хэлбэл 200 уг гэдэг бол бараг л ярчихаж болохоор монгол уг байна...гэж хэлээд сууж байна

0 0

saraa

Өчигдөр 10 цаг 33 минут

KHyataduudad KHushuutiig hudaltsan Demberelees arai deer dee

0 0

Зочин

Өчигдөр 12 цаг 37 минут

Солонгосуудад Дорнодын газрыг 100 жилээр зарсан Элбэгдорж ичиж үхээсэй. Түүний дэргэд Батbold бол юм үзсэн гар л даа. Арай ч Элбэгээ шиг хэдэн төгрөгөөр нутгаа худалдахгүй ээ

0 0

Зочин

Өнөөдөр 7 цаг 22 минут

Yun Elbegee vee. MAH-i nohduud, ter dundaa Badamjunai zarsan shuudee

0 0

Зочин

Өчигдөр 10 цаг 23 минут

Batbold sain eronhii saidaa. Tuuniig mullah hereggui ajlyg ni hilgие

1 1

Bado

Өчигдөр 9 цаг 35 минут

Novshiin huuhentei suusan hanaj tsadaha medehee baisan erunhii saiddaa Ene ailchil uurt ni ashigtai baina bizdee

0 0

Зочин

Өчигдөр 8 цаг 54 минут

Ulsaasaa bayan eronhii said mongoliin hamag altiig zarj bayjsan hun dee

0 0

Зочин

Өчигдөр 8 цаг 53 минут

Myy hogiin hulgaich luivarchin iim hulgaich eronhii said hiiheer mongol gejuls duusch baigaa n oilgomjtoi teneg uher mongolchuud iim adgiin shaariig songoj baidag hohi n

0 0

Зочин

Өчигдөр 12 цаг 38 минут

Хягад цустан минь Монгол сайдыг бүү хараа. Та нар Монголыг сэргэн мандахыг үзэхгүй.

0 0

Зочин

Өчигдөр 8 цаг 3 минут

ХН

